

## 01 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭ

### Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

#### Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл:

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс Аймгуудын өрсөлдөх чадварын тайланг 8 дахь жилдээ тодорхойлон үр дүнг танилцууллаа. Сүхбаатар аймаг 2018 онд 15 оноогоор ухарсан бол энэ жил 73.07 оноогоор 7-р байр эзэллээ.

Аймгийн Засаг даргын зөвлөл энэ сард 5 удаа хуралдан 8 асуудал хэлэцэн шийдвэрлэлээ.

Коронавирусын халдвар дэгдэхээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний бэлэн байдлыг хангах, улс, аймгийн Онцгой комиссын шийдвэрийн хэрэгжилтийг хангах, мэдээ мэдээллийг шуурхай солилцох үүрэг бүхий Шуурхай удирдлагын штабыг аймгийн Засаг даргын 36 дугаар захирамжаар томилон ажиллуулж байгаагийн зэрэгцээ “Шинэ Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, ажил эрчимжүүлэх тухай” аймгийн Засаг даргын 03 дугаар албан даалгаврыг батлан сумд, агентлаг, албад, аж ахуйн нэгж байгууллагуудад холбогдох үүрэг чиглэлийг өгч хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Аймгийн Онцгой комисс цаг үеийн асуудал, үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан 4 удаа хуралдаж холбогдох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээний чиглэлээр: Сум, агентлаг, төсөвт байгууллагаас 2019 оны үйл ажиллагааны тайланг цаасаар болон цахимаар хүлээн авлаа.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж биелэлтийг хугацаанд нь цахимаар болон цаасан байдлаар хүргүүлсэн. 2019 онд 63 хууль, тогтоомжийн 110 заалтыг хяналтандаа авч ажиллаж байгаа ба хэрэгжилтийг тооцоход 100 хувьтай 93, 70 хувьтай 16, 30 хувьтай 0, хэрэгжээгүй буюу 0 хувьтай 0, хэрэгжих хугацаа болоогүй 1 заалт байна. Хууль, тогтоомжийн биелэлтийн дундаж 95,6 хувьтай байна.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж биелэлтийг гаргаж тайланг хугацаанд цахимаар болон цаасан байдлаар хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөний 66 арга хэмжээг хяналтад авч, хэрэгжилтийг тооцон үзэхэд 100 хувьтай 52, 70 хувьтай 9, үнэлэх боломжгүй 5 заалт байна. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн дундаж 95,57 хувьтай байна.

Аймгийн эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Засаг даргын зөвлөлийн хурлаар хэрэлцүүлээ.

### Хоёр. Хууль эрх зүйн салбарт

Аймгийн Засаг даргын 2019 оны А/598 дугаар захирамжийн дагуу томилогдсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн Баруун-Урт сумын болон хөдөөгийн 12 сумын 254 аж ахуй нэгжийн хүнсний дэлгүүр, нийтийн хоолны үйлчилгээний газарт 10 дугаар сарын 18-наас 2 сарын хугацаанд доорх хууль, тогтоомж, стандарт дүрэм журмын дагуу аттестатчилалын хяналт шалгалтыг зохион байгуулж Хяналт шалгалтанд 216 аж ахуй нэгж хамруулсан ба тусгай зөвшөөрлийг цуцлуулах 114 зөвшөөрлөөс Мэргэжлийн хяналтын газар, Стандарт, хэмжил зүйн хэлтсийн хяналт шалгалтын улсын байцаагчийн үнэлгээний хуудсаар 30 аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрөл цуцлагдахаар, 18 аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрлийг 3 сараар түр түдгэлзүүлэх саналыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцууллаа.

Архивын тасаг : Лавлагаа 101, хуулбар 77 нийт 108 иргэдэд хөдөлмөрчдөд давхардсан тоогоор 429 гаруй хадгаламжийн нэгжээр үйлчилсэн.

Цахимд 7 хадгаламжийн нэгж буюу 418 хуудас баримтыг програмд шивж оруулаад байна.

**Цагдаагийн газар:** Цагдаагийн газрын Эрүүгийн Цагдаагийн Тасгаас малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр "Идэш" хэсэгчилсэн арга хэмжээг зохион явуулж, 29 удаагийн үйлдлээр бусдын 61 бод, 130 бог мал хулгайлж бусдад 74 сая төгрөгийн хохирол учруулсан 8 бүлэг, 21 холбогдогчтой хэргийг илрүүлэн холбогдох шалгалтыг хийж байна.

**Шүүхийн шинжилгээний алба:** Албаны бие бүрэлдэхүүн Цагдаагийн газрын шуурхай албаны бүрэлдэхүүнд орж ажиллан жижүүрт 30 удаа гарч ажилласнаас хүний амь нас хохирсон хэргийн дуудлаганд 4 удаа, хулгайн хэргийн дуудлаганд 12 удаа, зам тээврийн ослын дуудлаганд 4, бусад хэргийн дуудлаганд 2 удаа, нийт 21 удаа хэргийн газрын үзлэгт оролцон хэргийн газрын үзлэгээр гутлын мөр 18 ширхэг, гарын мөр 5 ширхэг, тээврийн хэрэгслийн мөр 20 ширхэг, бусад ул мөр 5 ширхэг, ул мөр илрээгүй үзлэгийн тоо 8 ширхэг нийт 57 ул мөр илрүүлж, бэхжүүлэн хураан авлаа.

Тус албанаас хүний биед гэмтлийн зэрэг тогтоох үзлэг 61 удаа хийснээс хүнд-2, хүндэвтэр-8, хөнгөн-25, гэмтлийн зэрэгт хамаарахгүй-14, гэмтлийн зэрэг тогтоогдоогүй-12 дүгнэлт гаргасан байна. Бэлгийн холбогдолтой-5 шинжилгээ хийсэн байна. Гэмт хэргийн болон бусад шалтгаанаар нас барсан 3 хүнд шүүх эмнэлгийн задлан шинжилгээ хийж дүгнэлт гаргалаа.

Живой скайнер ажлын станцаар нийт 5 хүний гарын дардасыг авч Адис-Папилоны ажлын станцын санг баяжуулан ажиллаа. Нийт 530 кадр гэрэл зураг авагдсан байх ба шинжилгээний 73, хэргийн газрын үзлэгийн 323, цогцосны гадна үзлэг болон задлан шинжилгээний 84, бусад ажиллагааны 50 кадр гэрэл зураг авагдсан.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар:** Хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн 172 ялтны гүйцэтгэх баримтыг бичгийг хүлээн авч гүйцэтгэх баримт бичгийг үндэслэн хувийн хэрэг нээж шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулснаар нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн 12 ялтны 5104 цагтай гүйцэтгэх хуудсыг тус тус хүлээн авч Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ, Сүхбаатар ойжуулалт сум дундын анги, Сүхбаатар хөгжил үйлдвэрлэл технологийн парктэй гэрээ байгуулан ажиллуулж ялын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Торгох ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэхдээ хууль журмыг баримтлан ажиллахын зэрэгцээ торгуулийн төлбөр төлөх тухай учир холбогдлыг иргэдэд сайтар ухуулан ойлгуулж, шүүхээс тогтоосон хугацааг харалгүйгээр мөнгөн торгуулийг сайн дураараа биелүүлэхийг сануулан ажилласнаар урьд оны үлдэгдэл болон шинээр ирсэн 21 гүйцэтгэх хуудасны 48020,0 төгрөгөөс бодиттой биелүүлсэн 13 ялтны 7200,0 төгрөгийг бүрэн биелүүлж орон нутгийн төсөвт төврүүлэн ажилласан.

Эрх хасах ялын урьд оны үлдэгдэл 24 гүйцэтгэх хуудасны 15758 хоногийн үлдэгдэл дээр шүүхээс шинээр ирсэн 1 гүйцэтгэх хуудасны 1825 хоног, нийт 14747 хоногийн гүйцэтгэх баримт бичигт хяналт тавин ажиллахаас гадна төрийн албанд ажиллах эрхийг хасах ялтай 1 ялтны, морин уралдаанд оролцох эрхийг хасах ялтай 1 ялтны, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах ялтай ялтны ялын биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.

**Улсын бүртгэлийн хэлтэс:** 2020 оны УИХ-ын сонгууль болохтой холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/126 тоот тушаалаар иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг 2020.02.01-ний өдрөөс МУИХ-ын сонгуулийн ээлжит сонгуулийн санал авах өдрийг дуустал зогсоосон.

01 дүгээр сарын байдлаар дараах бүртгэлийн үйлчилгээг иргэдэд үзүүлсэн байна.

- Эд хөрөнгийн эрхийн бүртгэл газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн 203 мэдүүлэг, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 221 мэдүүлэг
- 2020 оны 01 дүгээр сарын байдлаар улсын бүртгэлд бүртгэлтэй нийт хуулийн этгээдийн тоо 1170. Үүнээс ХК-2, ХХК-4, Төрийн бус байгууллага-113, ОНӨААТҮГ-22, Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар -1, төрийн бус байгууллага -137, нөхөрлөл 75, хоршоо-80, хдгаламж зээлийн хоршоо-4, сан-3, үйлдвэрчний эвлэлийн

байгууллага-42, шашны байгууллага-11, хэвлэл мэдээллийн байгууллага-2, татан буугда улсын бүртгэлээс хасагдсан -56

- Иргэний бүртгэлийн тасаг нь 2020 оны 01 сарын байдлаар нийт 126 төрөлт, гэрлэлт 24, гэрлэлт цуцлалт 11, үрчлэлт 4, эцэг тогтоолт 4, овог нэр өөрчлөлт 4, нас баралт 23 , , аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 51, үндэсний энгийн гадаад паспорт 131, шинээр олгосон иргэний цахим үнэмлэх 77, иргэн аж ахуй нэгжид олгосон лавлагаа 393 тус тус бүртгэгдэж олгосон байна.

### **Гурав. Нийгмийн бодлогын хүрээнд**

**Боловсролын чиглэлээр:** Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгтэй хамтран "Би залуу багш" хөтөлбөрийг эхлүүлж, тус хөтөлбөрийн хүрээнд БХАН-ийн сургагч багш нар ЕБС, СӨБ-д 1-15 дах жилдээ ажиллаж буй 101 залуу багшийг хамарсан сургалт зохион байгуулсан.

Сүхбаатар аймгийн боловсролыг 2020-2030 онд хөгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөө, байгууллага хөгжүүлэх төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй сургалт, зөвлөгөөн зохион байгуулсан ба боловсролын байгууллагын удирдах албан тушаалын 50 ажилтан хамрагдлаа. Сургалтыг менежментийн зөвлөх үйлчилгээний багийн ахлагч профессор Р.Батжаргал удирдан явуулав.

2019-2020 оны хичээлийн жилийн гарааны хөндлөнгийн үнэлгээг 16 сургуулийн 3-12-р ангийн 10550 сурагчаас 22 хичээлээр авч шалгалтын анализ болон сургалтын чанарыг дээшлүүлэх чиглэлээр дүгнэлт, зөвлөмжийг мэргэжил тус бүрээр хүргүүллээ.

**Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр:** Монголын эмэгтэйчүүдийн холбооноос зохион байгуулж байгаа "Соёлыг түгээе" төслийн нээлт 01 сарын 25-нд Сүхбаатар аймагт боллоо. Нээлтийн үйл ажиллагаанд сум бүрийн төлөөллөөс бүрдсэн 500 гаруй эмэгтэй хамрагдсан байна. Соёлыг түгээх багт МЭХ-ны ерөнхийлөгч Б.Оюунгэрэл, өв соёл түгээн дэлгэрүүлэгч МУСТА Б.Нарандэлгэр, жүжигчин МУСТА А.Ганчимэг нар багтжээ.

"Эцэг эхийн зөвлөл"-ийн сургалтыг Дөрвөлж ХХК, Боловсрол өргөө, 6-р цэцэрлэг зэрэг газруудын 140 албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж Аймгийн цагдаагийн газарт баривчлагдсан 20 иргэнд "Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалт", Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж ирсэн 7 хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөө , Шүүхийн шийдвэрээр хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээнд хамрагдаж буй 1 хүүхдэд 4 цагийн зан үйл засах сургалт хийсэн.

Боловсрол өргөө нэгдсэн дотуур, Цагдаагийн газар, 6-р цэцэрлэгийн 67 ажилтан албан хаагчдад ажлын байран дахь стрессийг хэрхэн зохицуулах, цахим донтолтоос хэрхэн урьдчилан сэргийлэх, харилцаа хандлагын тухай ойлголт, эерэг хандлагатай хүн ямар байх ёстой мөн уур бухимдлаа хэрхэн зохицуулах талаар сургалт зохион байгууллаа.

ЕБ-ын 4-р сургуулийн 164 сурагчид 01-р сарын 23-ны өдөр бүлийн, нийгмийн ,сургуулийн орчинд ямар аюулгүйн дүрмийг баримтлах талаарх заавар зөвлөгөө, архи тамхины хорт уршиг, цахим орчны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх сургалтуудыг тус тус зохион байгууллаа.

#### **Соёл урлагийн чиглэлээр:**

**Нийтийн номын сан:** 01 сард Уншигч -188, Ирэгсэд-433, Ном олголт-843.

Үндсэн хуулийн өдөрт зориулан 50 номоор үзэсгэлэн гарган зохион байгуулахад 120 гаруй хүн оролцож, давхардсан тоогоор 300 гаруй хүн хамрагдсан байна.

**Хөгжимт жүжгийн театр:** Жаахан шарга театрын "Өвлийн мишээл" цасны баярын арга хэмжээг Биеийн тамир спортын газар, BBS телевизтэй хамтран зохион байгуулсан ба дээрх арга хэмжээнд байгууллагын албан хаагчид өргөн бүрэлдэхүүнээр хамрагдаж 6 багт хуваагдан тусгай хөтөлбөрөөр зохион байгуулагдсан бөгөөд 01 дүгээр сарын 21-ний өдөр орон нутгийн BBS телевизээр тусгай нэвтрүүлэг болж цацагдсан.

Үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу барилга, байгууламж гадна талбай, зогсоолын хараа хяналтыг сайжруулах зорилгоор сүүлийн үеийн чанар нягтрал бүхий 16 ширхэг хяналтын камерыг шинээр суурилууллаа.

Бүжигчдийн ур чадварыг сайжруулах зорилгоор Улаанбаатар хот Чингэлтэй дүүргийн Соёлын ордны циркийн багш, жүжигчин Отгонбаатарын циркийн хөдөлгөөний техник, турукний ур чадварыг дээшлүүлэх сургалтыг 01 дүгээр сарын 20-с эхлэн 14 хоногийн хугацаатай зохион байгуулсан.

Театрын Дарга, Ерөнхий найруулагч, Хөгжмийн багш нарын бүрэлдэхүүнтэй баг ОХУ-ын Буриад улсад 01 дүгээр сарын 20-23-ний өдрүүдэд ажиллаж Бурдрам театрт хамтын ажиллагааг өргөжүүлэх, аялал тоглолт зохион байгуулах, уран бүтээлчдийн ур чадварын сургалт зэрэг тодорхой ажлуудыг хамтран зохион байгуулахаар болсон байна.

**Угсаатны зүйн музей:** Сүхбаатар аймгийн уугуул, ахмад археологич Д.Доржийн нэрэмжит “Чулуун соёлын өв” үзэсгэлэн түүхийн танхимд дэглэгдсэн. Уг үзэсгэлэнд ШУА-ын археологийн хүрээлэнгийн Захирал Г.Эрэгзэн/Ph.D/ дэд профессор, Археологийн хүрээлэнгийн эрдэмтэн н.Эрдэнэ-Очир доктор /Ph.D/ н.Одсүрэн /Ph.D/, Чулуун зэвсгийн секторын ЭША-н Г.Галдан докторант, С.Далантай докторант нар оролцлоо. Уг үзэсгэлэнд ШУА-ын археологийн хүрээлэнгээс 130 ширхэг чулуун зэвсгийн дурсгалыг шилжүүлэн өгч музейн сан хөмрөгийг баяжуулсан.

**Биеийн тамир, спортын талаар:** Жюү-Жицү Улсын аварга шалгаруулах тэмцээнд баг тамирчид 3 алтан медаль, 2 мөнгөн медаль, 2 хүрэл медаль хүртсэн амжилт үзүүлсэн.

Дорноговь аймгийн Замын-Үүд суманд зохион байгуулагдсан Зүүн бүсийн футзалны U-14, U-16 насны аварга шалгаруулах тэмцээнд 1 алт медаль, 1 хүрэл медаль хүртсэн.

Футзалны U-13, U-15 насны Улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож 6-р байр, 8-р байр тус тус эзэлсэн.

2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр “Шинэ оны анхны нар харах” авто аялал Талын наран арга хэмжээнд нийт 70 гаруй авто машин, 450 гаруй ард иргэд, албан хаагчид оролцсон. Уг арга хэмжээнд уурга шүүрэх, сумо бөхийн тэмцээн, хөгжөөнт буухиа, дээлтэй Монгол арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.

Монгол Улсад гал түймэртэй тэмцэх 98 жилийн ойн нэрэмжит Аймгийн Онцгой байдлын газрын ажилчин албан хаагчийн өдөрлөгийг хамтран зохион байгуулж 100 ажилтан албан хаагчийг гэр бүлийн хамт хамруулсан ба 4 төрөлийн тэмцээн уралдааныг зохион байгуулж шалгарууллаа.

2020 оны Аймгийн аварга шалгаруулах өсвөр үеийн шатрын тэмцээнийг зохион байгуулж 160 тамирчин оюун ухаанаа сорьж оролцсон.

Мөн 2020 оны Аймгийн аварга шалгаруулах өсвөр үеийн ширээний теннисний тэмцээнд 30 тамирчин, “Газар дэлхий” ХХК-ны 15 жилийн ойн нэрэмжит насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах ширээний теннисний тэмцээнд 35 тамирчин тус тус оролцсон.

**Эрүүл мэндийн чиглэлээр:** Томуу, томуу төст өвчний дэгдэлттэй холбогдуулан аймгийн Засаг даргын захирамж гарган СӨБ-ийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох арга хэмжээ авч томуугаас урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг байгууллагуудад болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол явуулж байна. Шинэ коронавирустэй сэргийлэх арга хэмжээг авч Нийгмийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулсан Шуурхай штабыг ажиллуулж аж ахуйн нэгж албан байгууллагаар явж үүрэг чиглэл өглөө.

Шинэ коронавирустэй сэргийлэх арга хэмжээний хүрээнд Бичигт боомтод ажлын хэсэг ажиллуулж хилийн боомтоор орж гарч байгаа иргэдэд эрүүл мэндийн үзлэг хийх эмч, сувилагчийг томилон ажиллуулж шаардлагатай арга хэмжээг авлаа.

Түвшинширээ сумын эрүүл мэндийн төвд орон нутгийн 31,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Уаз-пургон автомашин олголоо.

Баруун-Урт суманд үйл ажиллагаа явуулдаг цэцэрлэгийн туслах багш нарт Томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх, Хүүхдийн хоол тэжээл сургалтыг МХГазартай хамтран зохион байгуулж нийт 48 хүн хамрагдсан. Сургалтын хүрээнд хүнсний бүтээгдэхүүнийг хэрхэн

баяжуулах, давс хэрхэн бууруулах аргын дадлага сургалт хийж мэдлэгийн түвшин 27%-аар нэмэгдсэн байна.

ЭМС-ын 2013 оны “Эрүүл мэндийн статистик мэдээллийн талаар авах арга хэмжээний тухай” 450 дугаар тушаалын дагуу Сүхбаатар аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг 2020 оны 1 дүгээр сарын 20-25-ний өдрүүдэд ЭМЯ-ны ЭМХҮТөвд цаасан болон цахимаар тушаасан.

**Хөдөлмөр эрхлэлтийн талаар:** 2020 оны 01-р сарын байдлаар хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй ажил хайгч 981 иргэнээс эмэгтэй 478, бүртгэлтэй ажилгүй иргэн 728 иргэнээс, эмэгтэй 349 иргэн байна. 48 ажлын байрны захиалга бүртгэгдэж, 38 иргэнийг ажилд зуучилсан байна. Ажилд зуучлагдсан иргэдийн 36 иргэн буюу 94,7 % нь байнгын ажлын байртай болсон байна. Шинээр бий болсон 17 ажлын байрны мэдээллийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн. Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй Заж ахуй нэгж байгууллагын 49 гадаад/хятад/ ажилтныг монгол улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгоход байгуулгын зүгээс дэмжих саналыг олгож, хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан.

2014-2019 онуудад Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-н малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчин өрхийн үр тооцох судалгаа авсан.Хөгжүүлэх өрхийн гишүүдэд хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хэрэгжих төсөл хөтөлбөрийн мэдээллийг өгч нийтийг хамарсан ажил, бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээ, мэргэжил олгох болон хөдөлмөрт бэлтгэх сургалтанд хамрагдах хүсэлтэй иргэдийг бүртгэв.

**Нийгмийн халамжийн талаар:** 2020 оны 01-р сард 13 сумын нийгмийн халамжийн тэтгэмжийн 124, тэтгэврийн 17 , ахмадын хөнгөлөлтийн 55, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлтийн 100, 0-3 насны хүүхдээ асарч байгаа эхийн 90, жирэмсэн эхийн 145 нийт 531 хувийн хэргийг хүлээн авч хянан баталгаажуулж нийгмийн халамж үйлчилгээний мэдээллийн системд баталгаажуулсан.

Сумдын мэргэжилтнүүдээс тэтгэвэр тэтгэмж хөнгөлөлт тусламж авах 230 иргэдийн 2020 оны 01 дүгээр сард олгох 1217 иргэний 208323,7 мянган төгрөгийн тэтгэвэр , 1208 иргэний 110808,7 мянган төгрөгийн тэтгэмж , 48 иргэний 13050,5 мянган төгрөгийн ахмадын хөнгөлөлт, 270 иргэний 17786,2 мянган төгрөгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, 647 иргэний 22330,3 мянган төгрөгийн жирэмсэн эхийн тэтгэмж, 16 иргэний 2570,3 төгрөгийн алдар цолтой ахмадын хөнгөлөлт, 3264 иргэний 159696,4 мянган төгрөгийн 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжийн жагсаалтыг арилжааны банкуудад илгээн олгож байна.

Баруун-Урт сумын хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдсан өрхүүдэд хүнсний бүтээгдэхүүнээр үйлчилгээ үзүүлсэн “Хаан жимс”, “Баялгийн Ундрах”, “Ундрах”, “Чандмань дэлгэр ундрах” дэлгүүрийн 2019 оны гэрээний биелэлтийг дүгнэхэд 97 хувьтай үнэлэгдлээ.

Халзан суманд 2019 онд шинээр гэрээ байгуулсан “Эрдэнэ ЗММ” ХХК гэрээний биелэлт 100 хувь дүгнэгдэж гэрээг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сунгасан. Наран сумын хүнсний эрхийн бичгийн үйлчилгээний санхүүжилт жилийн 10 сая төгрөгнөөс доош байсан тул сумын засаг дарга ажлын хэсэг томилон суманд үйл ажиллагаа явуулж буй дэлгүүрүүдэд үнийн харьцуулалт хийн санхүүгийн чадавхитай “ББТБ” ХХК-тай 2020 онд хамтран ажиллах гэрээг байгуулсан.

11 сумын 16 хүнсний дэлгүүр сонгон шалгаруулах тендерийг Орон нутгийн өмчийн газраар зохион байгуулахаар ажлын төлөвлөгөөнд нь батлуулж, 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 02 дугаар сарын 21-ний дотор тендер сонгон шалгаруулалтыг зарлалаа.

Монгол Улсын Засгийн Газрын 96 дугаар тогтоолоор “Нийгмийн халамжийн тухай хууль”-ийн 13.1.5-д заасан хүүхдийн мөнгөн тэтгэмжийг өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн өрхийн 0-18 хүртэлх насны, хүүхдийн мөнгөн тэтгэмж авах хүсэлт гаргасан хүүхэд бүрд сар бүр бэлэн мөнгөөр олгох болсонтой холбоотой Сүхбаатар аймгийн хэмжээнд огт судалгаанд хамрагдаагүй өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэхээр хүсэлт гаргасан нийт 54 өргөдлийг хүлээн авч програмд шивсэн. Хүсэлт гаргасан өрхийн 52 өрхөөс судалгааг



бүрэн авч, 47 өрхийн судалгааг өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэж хяналт хийсэн төлөвт оруулж оноо бодогдоход бэлэн болсон байна. Асуулгын хуудас нь хөдөө сумдаас ирээгүй байгаа тул өрхийн мэдээллийн нэгдсэн санд 5 судалгаа бүртгэгдээгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 1 удаа хуралдаж нийт 11 хүүхэд орсон. Үүнээс: 5 хүүхэд шинээр тогтоолгож, 5 хүүхэд сунгагдаж, 1 хүүхэд цуцлагдсан.

Улаанбаатар хотын “ОЗОН СЕРВИС” ХХК-тай гэрээ байгуулан олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний сэргээн засах үйлчилгээг 20 ахмад настанд 4900,0 мянган төгрөгөөр үзүүлсэн. Үзүүлсэн сэргээн засах үйлчилгээг дурьдвал: төөнүүр, бумба, бариа засал, физик эмчилгээний аппарат, зөгийн балны татлага, шарлага, хаш чулуун ор зэрэг эмчилгээнүүдийг үзүүлсэн.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дэргэдэх ахмадын амралт сувилалд 2 ээлжинд 30 ахмад настныг амрууллаа. Амралт сувилалд амрагч нарт бариа засал, бумба, зөгийн балны татлага, шарлага, физик эмчилгээний аппарат, хаш чулуун ор, давсан зам зэрэг эмчилгээнүүдийг үзүүлсэн.

**Дөрөв. Хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчин, зам тээвэр, уул уурхайн хүрээнд:**

**Мал аж ахуйн чиглэлээр:** Засгийн Газрын 2019 оны 338 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын сайн малчин өрх, улсын хошой аварга малчин өрх шалгаруулах журам”-ын дагуу “Улсын хошой аварга малчин өрх”-өөр 2, “Улсын аварга малчин өрх”-өөр 6 малчин өрхийн материалыг аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн ХХААХҮЯ-нд хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын 2015 онд батлагдсан “Аймгийн сайн малчин шалгаруулах журам”-ын дагуу “Аймгийн сайн малчин”-д сумдаас нэр дэвшсэн 50 малчдын материалыг хүлээн авч, эмхтгэн 40 аймгийн сайн малчинг аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн шалгаруулсан.

МҮОНРТ-ийн ерөнхий захирлын 2018 оны А/18 тоот тушаалаар батлагдсан “Алтан төлийн эзэн шалгаруулах журам”-ын дагуу Алтан унаганы эзэнд 3, Алтан хурганы эзэнд 2, Алтан тугал, ишигний эзэнд тус бүр 1 малчны материалыг шалгаруулан МҮОНРТ, ХХААХҮЯ-нд тус тус хүргүүлсэн.

Бэлчээр ашиглалт, хамгаалалтыг сайжруулах чиглэлээр 2019 онд улсын болон орон нутгийн төсөв, төсөл, хөтөлбөрийн хүрээнд хийж гүйцэтгэсэн ажил, мал оторлох нөөц нутаг, орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газруудын судалгааг сумдаас авч нэгтгэн ХХААХҮЯ-ны Мал аж ахуйн хөгжлийн бодлогын зохицуулалтын газарт хүргүүлсэн.

Сумдаас инженерийн хийцтэй болон энгийн уурхайн худгийн тооллогыг худаг ашиглалтын 15 дугаар маягтаар нэгтгэн авч Мал аж ахуйн хөгжлийн бодлогын зохицуулалтын газарт хүргүүлсэн. Аймгийн хэмжээнд нийт бэлчээрт 2575 худаг ашиглаж байна.

Гүн өрмийн худгийн зориулалт, эзэмшигч, ерөнхий судалгааг гарган ялган тэмдэглээ хийж Байгаль орчин аялал жуулчлалын газарт хүргүүлсэн.

Сумдаас арьс ширний урамшууллын материалыг хүлээн авч программд оруулан 13 архивын нэгж үүсгэн архивласан. Үүнд адууны шир 1208, үхрийн шир 14844, хонины нэхий 91499, ямааны арьс 23413 нийт 130964 арьс, шир тушаасан байна.

Сумдаас 7 хоног бүрийн 4 дэх өдөр бүр өвөлжилтийн талаарх мэдээллийг авч ХХААХҮЯ, “Малчин” сэтгүүлд тус тус өгч ажилласан.

**Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний чиглэлээр:** Канад улсын гадаад хэргийн яамнаас санхүүжүүлэн Сүхбаатар аймагт 2 дахь жилдээ хэрэгжүүлж байгаа “Мерит” төслөөс санаачлан аймгийн Засаг даргын, Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуй газар, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн тахимын Сүхбаатар аймаг дахь салбар танхим хамтран Олборлох салбарыг үр дүнтэй зохион байгуулж, орон нутгийн үйлдвэрлэл бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааг хангаж, жижиг, дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийн чававхыг сайжруулан орон нутгийн эдийн засгийг сэргээж, тогтвортой өсөлтийг хангах зорилгоор ШУТИС-ын бизнесийн ахисан түвшний сургуулийн сургагч багш нарын бүрэлдэхүүний

“Маркетинг ба борлуулалт” сэдвийн хүрээн дэх 4 өдрийн сургалтыг нийт 5 сумын 30 гаруй үйлдвэр эрхлэгчдэд хүргэж сертификат олголоо.

**Байгаль орчин, аялал жуулчлал, газар зохион байгуулалтын чиглэлээр:**

Сумдын байгаль хамгаалагч нар хариуцсан нутаг дэвсгэртээ Биологийн төрөл зүйлд ажиглалт мониторингийг цаг тухай бүрт олон удаагийн давтамжтай хийж гүйцэтгэж байна. Үүнд:

- Мөнххаан сумын Баян-уул 2-р багийн нутаг Богд-ууланд байршиж байгаа аргаль хонинд 1 удаа мониторинг хийсэн. Идэвхитэн байгаль хамгаалагч Ц.Ариунбаатар, нөхөрлөлийн ахлагч Э.Мөнхбаяр, нартай хамтран аргаль хонины тооллого болон өвөлжилтийн байдалтай танилцаж ажилласан. Баян-уул 2-р багийн нутаг болох Богд-уул, Цав, Өлзийт, Ачат-Уяат гэсэн газруудаар 115 км явж тооллого хийхэд нүдээр хараагүй болно. 1ш угалз байсан гэсэн мэдээллийг 2-р багийн иргэн өгсөн. Нөхөрлөлийн ахлагч Э.Мөнхбаяр 1 сарын 11нд Хадан хөв гэдэг газар 1ш угалз байна гэсэн мэдээллийг өгсөн. Өвөлжилтийн хувьд цас их, өвсгүй аргаль нутагшдаг газар айл олноор өвөлжиж байна гэсэн мэдээллийг байгаль хамгаалагч нар өгч байна.
- Дарьганга сум ТХГН-т Нартын ууланд нутагшиж буй Аргаль хоньд БОАЖГ сумын байгаль хамгаалагч, Дарьгангын БЦГ-ын хамгаалалтын захиргаа хамтран хужир шүү тавьж биотехникийн арга хэмжээг авч ажилласан.Цаашид ховор ан амьтанд үргэлжлүүлэн шүү, өвс тавих шаардлагатай гэсэн мэдээллийг өгч байна. Иймээс байгаль хамгаалагч нарын мэдээлэл болон орон нутгийн удирдлагуудын цаг үеийн шуурхай мэдээлэлд үндэслэн БОАЖГ-аас дараах арга хэмжээг авч ажиллалаа.

Аймгийн хэмжээнд 6 сумын нутаг дэвсгэрт цагаан зудтай байгаатай холбогдуулж өвөлжилт хүндэрсэн сумын нутаг дэвсгэрт тархасан Ховор ан амьтаны байршил, тархац, тоо толгой, сүргийн бүтэцийг тогтоох, зэрлэг ан амьтанд цаашид авах арга хэмжээг төлөвлөх мониторинг хийх зорилгоор БОАЖГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу ажлын хэсэг Мөнххаан, Баяндэлгэр, Түвшинширээ, Дарьганга сумдад ажиллаж байна. Ажлын үр дүнд цас зуднаас шалтгаалан идэш тэжээлийн хомсдолд орсон зэрлэг ан амьтны амьдрах орчныг нь тэтгэх үүднээс Биотехникийн арга хэмжээг авч ажиллах юм.

**Хүрээлэн буй орчин,Хог хаягдалын менежментийг сайжруулах чиглэлээр:**

Монголчуудын уламжлалт баяр Цагаан сарыг тохиолдуулан БОАЖГ-аас нийт ард иргэд, орон нутгийг зорин ирж буй гадаад дотоодын жуулчдад зориулан “Цэвэрхэн шинэлцгээе” уриалгыг гарган иргэд рүү хандсан нөлөөллийн ажлыг хийж эхлүүлээд байна. ЦЭВЭРХЭН ШИНЭЛЭХ” тухай уриалгыг төрийн болон төрийн бус байгууллагад хүргэх, орон нутаг, байгууллагын фэйж хуудас, вэб сайт, групп болон фэйсбүүк цахим сүлжээгээр сурталчиллах ажлуудыг хийлээ.

**Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд:** Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Биеийн тамир спортын газар, Боловсрол соёл, урлагийн газар хамтран “Уул ус, байгаль дэлхийдээ хүндэтгэл үзүүлэх болон шинэ оны анхны нарнаас энерги авах, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, дээлтэй монгол арга хэмжээг сурталчлах, нийтийн биеийн тамирын арга хэмжээг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Шинэ оны анхны нар харах аялал”-ыг 2020 оны 1 дүгээр сарын 1-ны өдөр Баруун-Урт хотоос урагш 30 гаруй километр байх Баяншарга ууланд арав дах жилдээ амжилттай зохион байгууллаа. Арга хэмжээнд Баруун-Урт сум, Асгат сум, Халзан, Эрдэнэцагаан сумынхан оролцлоо. Шинэ оны анхны харах аяллаар “Мөнгөн өвөл-2020” монгол үндэстний өвлийн хувцасны үзүүлбэр болон сумо бөхийн барилдаан, хөгжөөнт буухиа, морьтон залуучуудын дунд ташуур шүүрэх тэмцээн зохион байгуулагдаж хуран цугласан олныг хөгжөөсөн юм. “Аялалд идэвхтэй оролцсон хамт олны шагналыг Цагдаагийн газар, Биеийн тамир спортын газрын хамт олон авлаа. Аялалд 100 гаруй машин, 630 гаруй хүн оролцсон томоохон арга хэмжээ боллоо. Жилээс жилд оролцогчдын тоо болон үйл ажиллагааны чанар, хүртээмж сайжирч өвлийн аялал жуулчлалын хөгжүүлэх эвент арга хэмжээ болж чадсанаараа онцлогтой юм.

Онгон суманд өвлийн аялал жуулчлалын хүрээнд иргэдийн амралт чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх бие бялдрыг чийрэгжүүлэх, хөдөлгөөний дутагдалаас сэргийлэх, биеийн

тамирын уралдаан тэмцээнд өргөнөөр хамруулах, цэвэр агаарт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор “МӨНГӨН ӨВӨЛ 2020” цасны баярын арга хэмжээг Хилийн цэргийн 0184-р ангитай хамтран зохион байгууллаа. Тэмцээнд нийт 6 багийн 300 иргэд оролцож 5төрлийн. /Уулын орой булаалдах, Олс таталт,Цасны сумо,Мөсөн шагай харваа, Буухиа/ тэмцээнээр авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн.

**Ойн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд:** Аймгийн төвийн нийтийн эзэмшлийн ногоон байгууламжинд тарьсан модонд өвөл, хаврын улиралд хийх арчилгааны зөвлөмжийг “Сүхбаатар-Ойжуулалт” Сум дундын ойн анги, “Ойжуулалт-Хайлааст” ХХК, “Шаргын модод цэцэрлэг” ХХК-иудад, сум орон нутгийн төрийн байгууллагууд албан тоотоор, цахимаар ард иргэдэд заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

**БОАЖГ-аас** 1 дүгээр сард байгууллагын вэб сайт болон фейсбүүк хуудсаар дамжуулан 7 төрлийн мэдээллийг давхардсан тоогоор 11146 иргэнд мэдээлэл хүргэж ажилласан байна.

**Уул уурхайн салбарт:** Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн 3 аж ахуй нэгжийн 6 өргөдлийг хүлээн авч цахим бүртгэлд оруулан ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газартай бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулан аймгийн нутаг дэвсгэрт Газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа “Макс ойл”, “Монголиа шин ий энерги”, “Вульф петролеум” ХХК-иудтай холбогдон үүссэн өрийг барагдуулах, аймгийн Засаг даргаас шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлагын талаар дээрх компаниудтай дахин уулзалт зохион байгуулж, эвлэрлийн гэрээ байгуулах боломжийг судлах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын А/27 дугаар захирамжаар байгуулан ажиллаж байна.

**Зам тээврийн салбарт:** 2020 онд улсын төсвийн хөрөнгөөр баригдах аймгийн төвийн авто замын 7 уулзварын гэрлэн дохио суурилуулах ажлын зураг төсөл, төсөвт өртгийн тооцоог шинэчлэн боловсруулах зөвлөх үйлчилгээг “Арбэл Алтай” ХХК-иар гүйцэтгүүлэхээр ажиллаж байна.

Баруун-Урт сумын 1-р баг “24 айл”, “60 айл” орчмын зам талбай, Грийн таун хорооллын баруун талаар урагшаа музейн урд тал 2-р тойргийн зам хүртэлх хатуу хучилттай авто замын зураг төсөл, төсөвт өртгийн тооцоо боловсруулах зөвлөх үйлчилгээний зургийн даалгавар боловсруулан батлуулж гүйцэтгэгч сонгон шалгаруулахаар аймгийн Өмчийн газарт хүргүүлээд байна.

### Тав. Бусад салбарт хийгдсэн ажил

**Стандарт хэмжил зүйн хэлтэс:** Стандартчилал, техникийн зохицуулалт, итгэмжлэлийн тохирлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилт, Засгын газрын 291-р тогтоол, Стандартчилал хэмжилзүйн газрын тогтоол, журам, дүрэм, Аймгийн засаг даргын захирамж, Хэлтсийн даргын үүрэг даалгавар зэргийг хэрэгжүүлэх хүрээнд 20 гаруй аж ахуй нэгжийн худалдаа үйлчилгээний газар тохирлын үнэлгээнд хамрагдсанаас: мухлаг-1, хүнсний дэлгүүр-3, минимаркет-6, Зоогийн газар- 3, пав караске-1, тус тус тохирлын гэрчилгээ олголоо.

Тайлант хугацаанд иргэн аж ахуй нэгж байгууллагаас өдөр тутам ирэх хэмжих хэрэгсэл баталгаажуулах, шалгалт тохируулга хийлгэх санал хүсэлтийг хүлээн авч барагдуулан ажилласан. Энэ ажлын хүрээнд электрон болон механик жин- 5, цусны даралтын аппарат-4, цахилгаан тоолуур-10, лабораторийн жин-2, тус тус баталгаажуулалт, шалгалт тохируулганд хамруулан ажилласан. Түүнчлэн 1 төрийн байгууллага, 2 төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагад 8 төрлийн 11 ш стандартын захиалга авч хэвлэн баталгаажуулан гаргаж өгч мэдээ мэдээллээр хангасан.

### Зургаа. Сумдад зохион байгуулагдсан ажил

#### **Баруун-Урт:**

“Улсын аварга малчин өрх” шалгаруулах болзол журамд нийцсэн 1 иргэн, Монголын үндэсний олон нийтийн радио телевизээс шалгаруулдаг “Алтан төлийн эзэн” шагналд 1 иргэн, “Аймгийн сайн малчин” шагналд 4 малчин, аймгийн Тэргүүний тариаланч шагналд 1



тариаланч, аймгийн ИТХ-аас шалгаруулдаг “Мөнгөн унага”-ны эзэн шагналд 1 малчныг тодорхойлоод байна.

Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам”-ын дагуу сумын орон тооны бус комисс 19 нэр төрлийн 482 ширхэг, 63.4 кг, 1427948 төгрөгийн үнэ бүхий түүхий эд бүтээгдэхүүнийг 7 дэлгүүрээс хураан авч, устгалд оруулсан.

Уртын гэгээ ОНӨААТҮГазар нь 2-р багийн замын 38 ш гэрэлтүүлгийг шинээр байршуулсан ба 3 орон сууцны дээвэрт 500м чимэглэлийн гэрэлтүүлэг, 12 ш том гэрэл хийсэн байна.

Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ нь нийтийн эзэмшлийн зам талбайн цас цэвэрлэгээний ажилд 9 тн давс, 3 тн бодис зарцуулсан байна. Нөөцөд 20 тн давс байна. Мөн энэ сард 286 тн хог зөөвөрлөж хаясан байна.

2,4,6-р багийн 100 иргэнийг Өрхийн ЭМТ-үүдтэй хамтран урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.

#### **Баяндэлгэр:**

**а/ Сумын ИТХ-ын чиглэлээр:** ИТХ-ын ажлын алба Монгол улсад шинэ хууль батлагдсаны 28 жилийн ойд зориулсан “АХА” уралдаант цэнгээнт тэмцээнийг албан газруудын дунд зохион байгууллаа.

Мөн Монгол улсын шинэ үндсэн хуульд шинээр орсон нэмэлт өөрчлөлтийн талаар ИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгч түүхийн багш Ж.Бадамханд сургалт мэдээлэл өгч ажилласан.

#### **б/ Тамгын газрын төрийн удирдлагын ажлын чиглэлээр:**

Шинээр төрсөн хүүхэд 9 бүртгэгдсэн. Үүнээс эмэгтэй 8, эрэгтэй 1 хүүхэд. Өөр аймаг хотоос шилжин ирсэн 3 иргэн.

Цагдаагийн тасаг, эрүүл мэндийн төвтэй хамтран цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, томуу томуу төст өвчнөөс хэрхэн сэргийлэх талаар сургалт зохион байгуулж 120 иргэдийг хамрууллаа.

Татварын хөнгөлөлт чөлөлөлтийн талаар төсөвт байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулсан.

**Хөдөлмөр эрхлэлт:** Шинээр ажлын байранд 10 иргэнийг бүртгэн зуучлан мэдээллийн нэгдсэн системд бүртгэсэн. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орон тооны бус ажилтанг төсөвт байгууллага бүр дээр томилон ажиллуулах саналыг албан байгууллагын удирдлагуудад тавьж энэ сараас эхлэн байгууллага бүр хариуцсан ажилтантай болж ажиллахаар болсон.

**Соёлын төв:** Соёлын төвийн хөгжмийн багш Баясгалан ятгын ганцаарчилсан дугуйланг 7 хоногт 3 цагаар 6-16 насны 8 сурагч, соёлын төвийн эрхлэгч морин хуурын дугуйлан хичээллүүлж 2 сурагч хамрагдаж байгаа бөгөөд заавал сурах нийтийн бүжгүүдийн сургалтыг 7 хоногийн 3 өдөр сонирхсон иргэдэд зааж сургаж байна.

Соёлын төвийн номын сан нь 158 хүнд гэрээр болон танхимаар 187 ном олгож ажиллаа. “Ахмадын дуун цэнгүүн-2020” шалгаруулалтын 1-р шатны бэлтгэл ажил хийгдэж байна.

**Байгаль орчин:** Мерсу Corp олон улсын байгууллагатай хамтран бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн доройтлыг бууруулах төслийн хөрөнгө батлуулах төлөвлөгөө боловсруулж тэргүүлэх 3 саналыг батлав.

**Хөдөө аж ахуй:** Сумын хоршооны гишүүн малчин болон мал бүхий этгээдийн 823 өрхийн 223 ширхэг адууны шир, 1124 ширхэг үхрийн шир, 23220 ширхэг хонины нэхий, 863 ширхэг ямааны арьс нийт 25430 ширхэг арьс ширний урамшуулалын материалыг программд шивж оруулан ХХААГазарын мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.

МҮОНТ-ын нэрэмжит алтан ишигний эзэнд 1 малчин, МУ-ын аварга малчинд 1 малчин, аймгийн аварга малчин 4 малчины тодорхойлолт материалуудыг ХХААГазарт хүргүүлсэн.

#### **Дарьганга:**

**Хууль эрх зүй:** Эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумын 4 багийн Засаг дарга нараар ахлуулсан 4 баг маршрут гаргаж, хөдөөгийн малчин өрхөөр “Гэрээр зочлох үйлчилгээ” хэлбэрээр үйл ажиллагааг зохион байгуулж байна. Уг ажлаар ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын талаар, Хог хаягдлын тухай хуулийн хүрээнд, Хоггүй хот айлыг шалгаруулах болзлын талаар, Цэргийн шинэчилсэн бүртгэлийн талаар, Өвөлжилтийн байдалтай танилцаж, иргэдийн санал хүсэлтийг сонсож тэмдэглэн авах хариуг өгөх зэрэг арга хэмжээг авч ажиллаж байна.

“Захиргааны хэм хэмжээний актыг гаргахад анхаарах нь” сэдвээр сумын ИТХ-ЗДТГ-ын албан хаагчдад сургалт хийж 16 албан хаагчийг хамрууллаа.

Сумын ЗДТГ-ын хууль, эрх зүйн мэргэжилтэн Цагдаагийн хэсэг, Соёлын төвтэй хамтран “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиас, Авлигын эсрэг хуулиас, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиас, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиас шинэлэг хэлбэрээр сургалт, сурталчилгаа зохион байгуулж, Цагдаагийн хэсгийн 209 оны ажлын тайланг сонслоо. Нийт 130 хүн оролцсон. Эдгээр иргэдээс 2 асуумжаар санал хүсэлт, зөвлөмжийг бичгээр хүлээн авахад нийт 84 хүнээс 71 нь цагдаагийн хэсгийн үйл ажиллагааг хангалттай сайн, 3 хүн огт бөглөөгүй, 10 хүн хангалтгүй гэсэн үнэлгээ өгсөн бөгөөд 27 хүн санал, зөвлөмж, хүсэлт бичиж ирүүлсэнд дүгнэлт хийж зохих арга хэмжээг авахаар ажиллаж байна.

Авлигын эсрэг хуулиас буюу нийтийн албан тушаалтанд хориглосон 8 зүйл, Авлигатай тэмцэх газрын 110 дугаарын утсанд үнэгүй ярьж мэдээлэл өгөх талаар бэлтгэсэн гарын авлагыг 100 ш олшруулан, мөн Татварын багц хуулийн 2020 оноос мөрдөж эхлэх 10 шинэлэг өөрчлөлийг тусгасан гарын авлага 100 ш бэлтгэн иргэд, төрийн албан хаагчдад тараах ажлыг хууль эрх зүйн мэргэжилтэн, Татварын байцаагч нар зохион байгуулж эхлээд байна.

**Эрүүл мэнд:** Томуугийн дэгдэлт нэмэгдсэнтэй холбогдуулан өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллаж, цаг үеийн мэдээг холбогдох газруудад тухай бүрт мэдээллэн ажиллаж байна. Мөн томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх сургалтыг үйлчлүүлэгчдэд болон хэвтэн эмчлүүлэгчдэд тогтмол хийж байна. Нийт 77 ширхэг гарын авлага, зөвлөмж тараасан. ЕБС-ийн 1-р ангийн сурагчдад томуу, томуу төст өвчний талаар мэдээ мэдээлэл зөвлөгөө өгч, цэгэн иллэг хийх арга дарааллыг зааж өгч ажилласан.

Эрүүл мэндийн газраас зохион байгуулж буй мал, амьтдын галзуу өвчний улиралчлал эхэлж байгаатай холбогдуулан ирсэн зөвлөмжийн дагуу “Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ”-ний талаар сургалтыг вакцинактор сувилагч, НЭМ-ийн ажилтан нар зохион байгуулж, 50ш гарын авлага тараан ажилласан.

**Байгаль орчин:** Хог хаягдлын хураамжийн хэмжээг тогтоох тухай сумын ИТХ-ын тогтоолын төслийг иргэдэд танилцуулан хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж, тогтоол шийдвэрийг Хууль зүй дотоод хэргийн яаманд бүртгүүлэхээр хүргүүлээд байна.

Уламжлал болгон зохион байгуулдаг “Хоггүй хот айл” шалгаруулах уралдааны болзлын шалгуурыг хөдөөгийн өрхүүдэд зохион байгуулж байна.

Сумын БЦГХЗ-наас санаачлан Нарт ууланд оршин байх аргаль, янгирын сүрэгт биотехнологийн арга хэмжээ авч, хивэг, өвс тавьж өгөх ажлыг зохион байгууллаа.

УЦУОШ-ний “Дарьганга өртөө” хариуцан өвлийн бэлчээрийн явуул судалгааг 5 цэгт хийж, цасны нягт 0,17-0,20 гр/см, дундаж зузаан 10 см, хунгар 15 см-20 см байна гэж тогтоолоо.

**Боловсрол, соёл:** Зэргэлдээ орших Наран сумын ахмадууд Дарьганга сумын ахмадуудын нөхөрсөг уулзалт цэнгүүн зохион байгуулахад 160 гаруй ахмад оролцлоо.

Сумын Соёлын төвийн хамт олон 2020.01.09 нээс 10 ны өдрүүдэд Эрдэнэцагаан сумын Соёлын төвийн үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах уулзалт зохион байгууллаа.

БСШУСЯ-ны СУБГ-ын дарга 2020.01.10 ны өдрийн 7/129 тоот албан бичгээр ирүүлсэн улсын хэмжээнд зохион байгуулагдах “МОНГОЛ НААДГАЙ-2020” аяныг зохион байгуулах зөвлөмжийг хэрэгжүүлж, үндэсний агуулга болох уламжлалт тоглоом наадгайг нийтийн

хүртээл болгохоор оюун ухааны “ШАТРЫН КЛУБ”-ыг сумын Соёлын төвийн дэргэд нэг багштайгаар нээн ажиллуулж 3-4 насны хүүхдүүдийг хамруулж эхэллээ.

**Мөнххаан:**

Сумын Засаг даргын 2020 оны А/02 дугаар захирамжаар 2020 оны Хүн ам орон сууцны ээлжит тооллогын ажлын хэсгийг томилон 01/06-01/15 ныг хүртэлх хугацаанд түүврээр сонгогдсон хөдөөгийн багуудын айл өрхүүдээр явж тооллогын ажлыг хийж гүйцэтгэсэн. Нийт 150 өрхийн 593 хүн тоологдсон. Тооллогын ажлын зардалд 3395.0 төгрөгийг зарцуулан ажилласан.

**Хөдөө аж ахуй:** Хувийн хэвшлийн 5 мал эмнэлэг нь Мал эмнэлгийн ариун цэврийн гэрчилгээ цахимд шилжиж 442 иргэнд олгоод байна.

**Байгаль орчин:** Агаар бохирдуулагч эх үүсвэрт нэгдсэн тоо бүртгэл явуулах ажлын хэсэг 2020/01/06-ны өдрийн А/16 дугаар захирамжаар байгуулагдаж удирдамжийн дагуу тооллогыг явуулж байна.

Сумын аж ахуйн нэгж байгууллагууд өөрийн эзэмшлийн талбайд халтиргаа гулгаа үүссэнтэй холбогдуулан сумын Засаг даргын А/06 дугаар захирамжийн дагуу цас цэвэрлэгээний ажлыг зохион байгууллаа. Нийт 5 төсөвт байгууллага, 18 аж ахуйн нэгж хамрагдсан. Зориулалтын бус газар хог хаягдал хаясан иргэдэд шаардлага хүргүүлж гарсан зөрчлийг арилгуулж 50,0 төгрөгийн торгууль 1 иргэнд ногдуулсан.

**Хөдөлмөр эрхлэлт, халамж:** ХАБЭА-н тухай хууль болон аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутагт хангуулах зорилгоор төсөвт байгууллагуудыг ХАБЭА-н ажилтантай болох талаар чиглэл өгч ажилласны үр дүнд ажилтантай ЗДТГазар, ЭМТөв, ЕБС гэсэн 3 байгууллага ХАБЭА-н ажилтанг шинээр томилон ажилуулахаар тушаал гаргасан.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сан LMIS программд идэвхтэй ажил хайж буй 63 иргэний мэдээлэл, идэвхигүй бүртгэлтэй 136 ажилгүй иргэдийн мэдээллээс 21 иргэний мэдээллийг эргэн сэргээж, 115 иргэний мэдээллийг устгалаа. Шинээр 3 иргэн бүртгэж нийт 87 ажилгүй иргэн бүртгэлтэй байна.

2019 онд Хамтран ажилласан Улаанбаатар хотын “Тэгш-Оршихуй” нүдний шилний газраас нийт 51 иргэнд нүдний шил захиалгаар хийлгэж 2020 оны 1 сард захиалгын дагуу бүрэн олгож дууслаа.

**Нийгмийн даатгал :** Эрүүл мэндийн даатгалд 86 иргэн даатгуулж 1748700 төгрөгийг төвлөрүүлсэн. Сайн дурын даатгуулагчдын гэрээг сунгаж баталгаажуулсан нийт 104 иргэний гэрээг сунгаж 9990902 мян төгрөгийг харилцах дансанд төвлөрүүлсэн.

**Боловсрол:** Ерөнхий Боловсролын сургуулийн 7-16 дах жилдээ ажиллаж буй багш нар энэ оны 01 дүгээр сарын 20-23-ний өдрүүдэд “Бусдаасаа суралцъя – Туршлагаа түгээе” сэдэвт үзүүлэх хичээлийг зохион байгуулсан.

Тус сургуулийн залуу багш нарыг дэмжих, арга зүйгээр чадавхжуулах зорилгоор энэ оны 01 дүгээр сард Баруун Урт хотод зохион байгуулагдсан тус чиглэлийн сургалтанд 5 багшийг 2 хоногийн хугацаатай хамруулаад байна.

Мөнххаан сумын Цагдаагийн хэсгээс тус сургуулийн нийт багш ажилчид, сурагчдын дунд “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль”-ийн танилцуулгыг хийж шаардлагатай зөвлөмж, зөвлөгөөнүүдийг өгч ажиллалаа. Тус үйл ажиллагаанд Ерөнхий Боловсролын сургуулийн багш ажилчдын 80% нь хамрагдсан бөгөөд мөн дунд ахлах ангийн сурагчдыг хамрууллаа.

Мөнххаан сумын ИТХ, Дашчойнхорлин хийд, ЕБС хамтран Монгол улс эрх чөлөө тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 108 жилийн ойг тохиолдуулан “Эрх чөлөө-Тусгаар тогтнол” яруу найргийн наадмыг 3 шаттайгаар зохион байгууллаа. Тус наадмын дараагийн шат 2020 оны 02 сарын 16-нд Баруун-Урт хотод зохион байгуулагдах бөгөөд наадмын эхний 3 байранд орсон сурагчид Сүхбаатар аймгийн нийт ЕБС-уудаас шалгарсан сурагчидтай өрсөлдөнө.

**Сургууль:** Ерөнхий Боловсролын сургуулийн 7-16 дах жилдээ ажиллаж буй багш нар энэ оны 01 дүгээр сарын 20-23-ний өдрүүдэд “Бусдаасаа суралцъя – Туршлагаа түгээе” сэдэвт

үзүүлэх хичээлийг зохион байгуулсан. Тус сургуулийн залуу багш нарыг дэмжих, арга зүйгээр чадавхжуулах зорилгоор энэ оны 01 дүгээр сард Баруун Урт хотод зохион байгуулагдсан тус чиглэлийн сургалтанд 5 багшийг 2 хоногийн хугацаатай хамруулаад байна. Мөнххаан сумын Цагдаагийн хэсгээс тус сургуулийн нийт багш ажилчид, сурагчдын дунд “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль”-ийн танилцуулгыг хийж шаардлагатай зөвлөмж, зөвлөгөөнүүдийг өгч ажиллалаа. Тус үйл ажиллагаанд Ерөнхий Боловсролын сургуулийн багш ажилчдын 80% нь хамрагдсан бөгөөд мөн дунд ахлах ангийн сурагчдын дунд тус танилцуулгыг зохион байгуулсан. Мөнххаан сумын ИТХ, Дашчойнхорлин хийд, ЕБС хамтран Монгол улс эрх чөлөө тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 108 жилийн ойг тохиолдуулан “Эрх чөлөө-Тусгаар тогтнол” яруу найргийн наадмы 3 шаттайгаар амжилттай зохион байгууллаа. Яруу найргийн наадамд тус сургуулийн 12а ангийн сурагч Б.Одмаа Тэргүүн байр, 10б ангийн сурагч Энхтөгөлдөр Дэд байр, 10а ангийн сурагч Т.Отгонмөнх Гутгаар байр, 6в ангийн сурагч Жавзандулам, 6б ангийн сурагч Юмжирмаа нар Тусгай байрыг тус тус эзэллээ. Тус наадмын дараагийн шат 2020 оны 02 сарын 16-нд Баруун-Урт хотод зохион байгуулагдах бөгөөд тус наадмын эхний 3 байранд орсон сурагчид Сүхбаатар аймгийн нийт ЕБС-иудаас шалгарсан сурагчидтай өрсөлдөнө.

**Хүүхдийн цэцэрлэг:** Ханиад томуунаас урьдчилан сэргийлэх зөвлөмж, ажлын чиглэлүүд ирсэнтэй холбоотойгоор бүлгийн багш нар эцэг эхчүүдэд ханиад томууны талаар мэдээ мэдээллийг тогтмол мэдээллийн самбараар болон ангийн цахим хаягаар тогтмол зөвлөгөө, зөвлөмжийг өгч ажиллаж байна.

10 бүлгийн хүүхдүүдийн дунд “**ХӨГЖИЛТЭЙ ӨГЛӨӨНИЙ ДАСГАЛ**” хөгжимт үйл ажиллагааг зохион явууллаа. Энэхүү үйл ажиллагаанд нийт 219 хүүхэд хамрагдаж, бүлгийн багш нар бэлтгэл зохион байгуулалттайгаар оролцлоо.

**Эрүүл мэнд:** Аймгийн ЭМГазраас зохион байгуулсан “Мөнххаан сумын ЭМТөвийн дархлаажуулалт болон халдварт өвчний үеийн тусгаарлах өрөөний бэлэн байдал, үйл ажиллагааг танилцуулах үзүүлэх сургууль амжилттай зохион байгуулагдлаа. Энэ арга хэмжээнд АНЭ болон 12 сумын төлөөлөл нийт 23 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ирж үйл ажиллагааг сонирхож туршлага судалсан.

“Осол гэмтлээс сэргийлэх” 14 хоногийн аяныг ЭМГазраас зохион байгуулах удирдамж ирсний дагуу төлөвлөгөө боловруулан батлуулж дараах үйл ажиллагааг зохион байгуулж байна.

- Хурдан морь унадаг хүүхдийн судалгааг гаргаж ясны сийрэгжилтийн шинжилгээнд хамрагдах хүүхдийн судалгааг гаргасан.

- 9-12 хүүхдийн дунд мотоцикль унадаг хүүхдийн судалгааг гаргаж сургалтыг зохион байгуулсан. Нийт 62 хүүхэд хамрагдсан.

**Соёлын төв:** Соёлын төвийн дэргэдэх Эгшиглэнт аялгуу дугуйланд морин хуур 20, ардын болоод цэнгээнт бүжиг 35, цахилгаан хөгжимд 5, ятга ёочин хөгжмийн дугуйланд 7 нийт 67 сурагчид дугуйланд хамрагдан суралцаж байна.

Солёын төвийн номын сангийн олон нийтийн ажил 2 удаа, нийт уншлаганд 120 ном гарч 96 хүүхэд, 45 насанд хүрэгчдэд номоор үйлчилсэн.

1-р сард соёл урлаг дугуйлангийн үйл ажиллагаанд 1200 гаруй иргэд хүүхэд багачууд хамрагдсан байна.

### **Наран:**

Зудын эрсдэлийн судалгааг хийж аймгийн Онцгой Байдлын газарт хүргүүлсэн.

Засаг дарга болон Тамгын газрын холбогдох албан тушаалтнуудад хандаж 44 өргөдөл гомдол ирүүлсэнээс хугацаанд шийдвэрлэсэн 43, хугацаа болоогүй 1 өргөдөл гомдол байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 97.7 хувьтай байна.

Гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөрийн нөхцөл байдлын үнэлгээг 3 багийн 12 өрхөд хийлээ.

2020 оны хүн ам орон сууцны ээлжит тооллогыг сумын Засаг даргын 2019 оны А/15 дугаар захирамжаар томилогдсон тооллогын комисс 2020 оны 01 сарын 09-15ны хооронд зохион байгууллаа. Сумын нийт хүн амын 10 хувь буюу 50 өрх түүврээр хамрагдсан ба 1-р баг 15 өрх, 2-р баг 20 өрх, 3-р баг 15 өрх тоологдлоо. Сумын түр товчооны дарга сумын төвийн 14 өрхөөр хяналтаар явж ажилласан.

7-9-р ангийн эрэгтэй сурагчдад “Шагайн харваа”-ны сургалтыг зохион байгуулж, анхан шатны мэдлэг олголоо.

Ахмадын хороотой хамтран сар бүрийн 15-ны өдрийг “Ахмадын өдөр” болгож долоо хоног бүрийн 1,5 дахь өдөр бүжгийн сургалтын өдөр болгон ажиллаж байна.

“Жаргал дүүрэн аялал” ТББ сумын ахмадуудтай хамтран 01-р сарын 22-ны өдрийн 13 цагаас “Хөгжилтэй өдөр” цэнгүүн, 17 цагаас урлагийн тоглолт зохион байгууллаа.

### **Сүхбаатар:**

Сумын ИТХ-ын ээлжит 8 дугаар хуралдаан 2020 оны 01 дугаар сарын 03-нд 90 хувийн ирцтэйгээр хуралдаж 5 асуудлыг хэлэлцсэн. Үүнд:

- Сумын 2016-2020 онд хөгжүүлэх Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2019 оны үндсэн чиглэлийг “Хангалттай” хэрэгжсэн гэж дүгнэсэн.

- Сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2020 оны үндсэн чиглэл, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг баталсан.

- 2020 онд ОНХС-д 2.311.988,2 төгрөг, Боловсрол, Эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 1.722.134,4 төгрөг, Сум хөгжүүлэх санг 90.000.0 төгрөгөөр тус тус баталж салбар бүрийг хамарсан томоохон хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг хийхээр төлөвлөлөө.

2020.01.01-нд шинэ оны “Анхны нар харах” арга хэмжээг сумын ЗДТГазар, БОТасгаас хамтран зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд олон төрлийн тэмцээн уралдаан зохион байгуулж шалгаруулсан.

Сумын хэмжээнд нийт өрх 1040 болж өмнөх оноос 24 өрхөөр өссөн байна. Нийт хүн ам 3346 болж өмнөх оноос 13 хүнээр өссөн байна. Эрэгтэй 1872 хүн, эмэгтэй 1564 хүн амьдарч байна. Малтай өрх 841, малчин өрх 669, малчдын тоо 1199 байна.

Сумын хэмжээнд мал 359718 болж 4 төрөл дээрээ өссөн байна. Үүнээс тэмээ 1117 толгой, адуу 32549 толгой, үхэр 23076 толгой, хонь 201592 толгой, ямаа 101384 толгой болж өмнөх оноос 28509 толгой малаар буюу тэмээ 22-оор ухарч, адуу 686 толгой, үхэр 2063 толгой, хонь 18390 толгой, ямаа 7392 толгой малаар тус тус өссөн байна.

**Эрүүл мэнд:** сумын Засаг даргын Тамгын газар нь Дорнод аймаг дахь Бүсийн оношилгооны төвд албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах ажлыг төлөвлөж 2020.01.20-22-ны өдрүүдэд 1 дүгээр ээлжийн 13 албан хаагчийг 11 төрлийн үзлэг шинжилгээнд хамруулсан.

**Соёл:** Монголын уламжлалт ёс заншлыг түгээн дэлгэрүүлэх, хөгжүүлэх, бахархах сэтгэлийг төрүүлэх зорилгоор “**ДӨРВӨН БЭРХ**” тэмцээнийг албан байгууллагуудын дунд зохион явуулж шалгаруулсан.

### **Түвшинширээ:**

200 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн шинэ барилгыг аймгийн Засаг даргын А/681 дүгээр захирамжаар томилогдсон 19 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирж хүлээлцүүллээ. Барилгад 1 жил зүгшрүүлэлт, 3 жилийн баталгаа өгч, дутуу ажлуудыг 4 дүгээр сарын 2 дугаар долоо хоногоос ирж гүйцэтгэхээр хуваарь гаргуулан баталгаажууллаа.

Сумын ИТХурлын 2020.01.20-ны өдрийн 02 дугаар тогтоолоор батлагдсан 2019 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг иргэдэд сурталчлан ажиллаж байна. Энэ сард газар өмчлөх эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх-1 газар өмчлөн хүсэлт өргөдөл 13-ыг тус тус хүлээж аваад байна.



Сангийн сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 192,А/243 дугаар тушаалыг сум орон нутагтаа хэрэгжүүлэх, хог хаядал үүсгэсний, үйлчилгээний, хураамжийн хэмжээ үнэлгээг тогтоох зорилгоор иргэдээс санал асуулга авч сумын ИТХ-аар оруулж батлуулсан.

**Боловсрол:** “Дүрэмт хувцасаа зөв сайхан өмсцгөө” сарын аяныг 2020 оны 1 сарын 13-аас эхлэн өрнүүлж байна.

ХҮҮХДЭЭ СОНСЪЁ” хэлэлцүүлэг зохион байгуулж сургуулийн удирдлагууд хүлээн авч уулзлаа.

БСШУСЯ-наас Дэлхийн банкны хөнгөлттэй зээлээр хэрэгжүүлж байгаа “Мэдлэгийн эх – Миний дотуур байр”, “Багшийн хөгжил- Бидний амжилт” сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд хэвлэх төхөөрөмж, номын тавиур, бусад эд зүйлийг сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд

**Соёл:** 17-р жарны урвуулагч хэмээх шарагчин гахай жилийн аймгийн аврага шалгаруулах “Үндэсний шагайн харваа” тэмцээнийг хамтран зохион байгууллаа. д байгууллагын ажилчид ая дуугаа өргөн, хөгжим техникээр ханган ажиллаа.

### Түмэнцогт:

Сүхбаатар аймгийн Цагдаагийн газрын ахлах мөрдөгчийн мэдэгдлийн дагуу энэ сард 7 байгууллагын 90 гаруй албан хаагчид, Улсын чанартай авто замаар зорчсон болон сумын төв дотор хөдөлгөөнд оролцож байгаа 420 гаруй жолоочид замын хөдөлгөөний АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ олшруулан тарааж, замын хөдөлгөөнд соёлтой боловсон оролцох зөвлөмж өгсөн.

Нийгмийн даатгалын ерөнхий газраас баталсан малчин,ажил хөдөлмөр эрхлээгүй иргэний нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох хуулийн чиглэлийн талаарх мэдээллийг нийт 115 иргэнд хүргэсэн.

**Эрүүл мэнд:** Коронавирусын халдвараас сэргийлж эмч эмнэлгийн ажилчид бэлэн байдалд уртасгасан цагаар ажиллаж байна.

### Уулбаян:

Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх 13 ажил хийгдэхээс 12 ажил хийгдэж 158553,0 мян төгрөг төлөвлөснөөс 135000,9 мян төгрөгийн гүйцэтгэл гарч 85,1 хувийн биелэлтэй.Үүнд 2 цахим тендер зарлаж, 10 ажлыг шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн.

**Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт:** 2020 онд хэрэгжих төсөл хөтөлбөрүүд түүнд хэрхэн хамрагдах талаар иргэдэд мэдээлэл хийлээ. Хөдөлмөр эрхлэлтийн LMIS программд идэвхитэй ажил хайж буй 103 иргэний мэдээллийг шинэчлэн сэргээж эмэгтэй-50, сумын Засаг даргын нөөцөөс малжуулах төсөлд зорилтот 4 өрхийг хамрууллаа.

Шинээр ажлын байранд 12 иргэн эмэгтэй 7 зуучлан мэдээллийн нэгдсэн системд бүртгэсэн. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орон тооны бус ажилтанг төсвийн байгууллага бүр дээр томилон ажиллуулах санал тавьж 2020 оны 1 сараас эхлэн байгууллага бүр хариуцсан ажилтантай болсон.

**Боловсрол:** 2020 оны ширээний теннисийн АЙМГИЙН АВАРГА шалгаруулах тэмцээнд 9-12 насанд 2 сурагч, 13-15 насанд 2 сурагч оролцож 1 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр 5-р байрандорсон.

### Халзан:

Хурлын төлөөлөгч нарт хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах, тайлагнах талаарх сургалтыг зохион байгуулж хүн тус бүрээр хөрөнгө орлогын мэдүүлгийн авч хянан баталгаажуулан ажилласан.

Зорилтод өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд заавал хөгжих өрхүүдээр сонгогдсон 23 өрхийн гишүүдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар гэр бүлийн харилцаа, сургуульд хамрагдалт сэдвээр 2 удаагийн сургалт хийж мэдээ мэдээлэл өгч ажилласан.

ТГ-ын дарга, СА-ны дарга, ТГ-ын мэргэжилтэн есөн хүний албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 42 дугаар тогтоолоор зөвшөөрснийг Сумын засаг даргын захирамж болон Тамгын газрын даргын тушаалаар баталгаажууллаа.

2019 онд хийж хэрэгжүүлсэн онцлог ажлын тайланг орон нутгийн “Сүхбаатарын өнгө” сонинд хэвлүүллээ.

Заавал хөгжих 23 өрхөд “Гэр бүлийн боловсрол” сэдвээр сургалтыг зохион байгуулсан. Сургалтын үр дүнд гэр бүлийн гишүүддээ сэтгэлийн үгээ бичиж идэвхитэй оролцлоо.

"Осол гэмтлээс урьдчилан сэргийлье" аяны хүрээнд Цагдаагийн газраас "Зам тээврийн ослын өнөөгийн байдал, шалтгаан нөхцөл" "Ятгах тусам нягтал" нөлөөллийн арга хэмжээний хүрээнд "Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх" чиглэлээр яриа таниулга хийж иргэдээс санал хүсэлтийг сонсож ажиллалаа.

**Хөдөлмөр эрхлэлт:** Ажил хайгч иргэн 20, шинэ ажлын байр 4, ажил зуучлалаар 7 иргэнийг хөдөлмөрийн мэдээллийн санд бүртгэсэн.

**Мал эмнэлэг:** Мал эмнэлгийн цахим систем нэвтэрсэнээр хувийн хэвшлийн мал эмнэлгийн малын эмч нар 80 гаруй жор бичээд байна. Цахим систем нэвтэрсэнээр малын гарал үүслийн бичиг авахад хялбар түргэн шуурхай болсоны зэрэгцээ хулгайн мал тээвэрлэх асуудал дээр маш өндөр хяналттай болсон.

Мал мах авдаг ААН, иргэнд мэдэгдэх хуудас хүргүүлж зөрчил дутагдлыг арилгуулан ажиллаж байна.

Хувийн хэвшлийн мал эмнэлэг үүсч хөгжсөний 20 жилийн ой “Мал эмнэлгийн нэг өдөр” өдөрлөгийг Аймгийн мал эмнэлгийн газар, хувийн хэвшлийн мал эмнэлэг, ЗДТГ-тай хамтран зохион байууллаа.

**ЖДҮйлдвэр, Сум хөгжүүлэх сан:** 01-р сарын 27-ны байдлаар нийт 18 зээлдэгч байгаагаас 2020 оны 01 сарын зээлийн эргэн төлөлтийн орлого 7 хүнээс 1860000 мянган төгрөгний орлого Сум хөгжүүлэх сангийн дансанд төвлөрүүлсэн байна.

### Эрдэнэцагаан:

Тус сум нь 2019 оны хүн ам малын жилийн эцсийн тооллогыг амжилттай зохион байгуулж ажиллаа. Тооллогын дүнгээр 6769 хүн амтай 1925 өрхтэй шинээр 148 хүүхэд төрж 137 хүн шилжин ирж, 277 хүн шилжин явсан байна. ХАА салбарт мал 3 төрөл дээр өсч нийт 380974 толгой мал тоолуулсан байна. үүнээс адуу 46113, үхэр 29533, тэмээ 690, хонь 148606, 156032 тус тус тоолуулсан байна. Шинээр 21 мянгат малчин төрж сумын хэмжээнд 90 мянгат малчинтай болсон байна.

БНХАУ-д Корона вирусийн халвар дэгдсэнтэй холбогдуулан сумын онцгой комисс 2 удаа хуралдаж хүн амыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээ авч ажиллаж байна. Эрдэнэцагаан сумын Бичигтийн боомтоор дамжуулан БНХАУ-д ажиллаж байгаа 280 иргэнийг нутагт нь авчирлаа.

Түр хугацаагаар /10 хоног/ 18 цагаас хойш архи согтууруулах ундаагаар үйлчлэхгүй байх Сумын засаг даргын захирамжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн хувийн хэвшлийн 44 аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийж барааны үнийн зохиомол өсөлт бий болгохгүй байх талаар анхааруулж ажиллалаа.

